



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/56

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох,  
хүчингүй болгох, эрх сэргээх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.4, 10.1.5 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 19.18, 19.20, 19.23 дахь хэсэг, Эрүүл мэндийн яамны "Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс"-ын 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох байгууллагын нэрсийг нэгдүгээр, өөрсдийн хүсэлтээр хүчингүй болгох байгууллагын нэрсийг хоёрдугаар, эрх сэргээх байгууллагын нэрийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Б.Цогтбаатар/-т үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

2020-A-tushaal

141200231

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 02  
дүгээр сарын 03 -ны өдрийн 4/56  
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Эрүүл мэнд, эм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа  
эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох  
байгууллагын нэр, чиглэл, хугацаа


№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
Шинээр тусгай зөвшөөрөл олгох байгууллага			
1	Асралт мед ХХК	Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагаа эрхлэх	3 жил
2	Өү Ти Солюшн ХХК	Ахуйн шавьж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис импортлох, ханган нийлүүлэх	3 жил
3	Мед импорт монгол ХХК	Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
4	Реактив ХХК	Ахуйн шавьж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх бодис импортлох, ханган нийлүүлэх	3 жил
Нэмэлтээр тусгай зөвшөөрөл олгох байгууллага			
1	Экспресс оношилгооны төв ХХК	Эмнэлгийн багаж, сэлбэг, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг ханган нийлүүлэх	3 жил

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 12  
дүгээр сарын 03-ны өдрийн 1/86  
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрлийг өөрсдийн хүсэлтээр хүчингүй болгох  
байгууллагын нэр, чиглэл

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1.	АШУУИС, нүүр ам судлалын сургууль	Шүд, эрүү нүүрний тусламж, үйлчилгээг амбулаториор үзүүлэх чиглэлийг үлдээн, 10 орны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох
2	Нүүдэлчин соёлын өргөө ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх

Эрүүл мэндийн сайдын 2020 оны <sup>02</sup> дүгээр сарын <sup>03</sup> -ны өдрийн <sup>А/Б</sup> дугаар тушаалын гуравдугаар хавсралт



Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай  
Зөвшөөрлийн эрх сэргээх байгууллагын нэр, чиглэл

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1.	Үлэмж грийс ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх